

# Орон бүхний пролетариат нар нэгдэгтүн!

# АНХ ДУГААР

# ТАВАНЖИЛ

Төв аймгийн Намын Хороо, А.Д.Х-ын гүйцэтгэх захиргааны сонин

27 дахь  
жилдээ

№ 49 (2313)

1974 оны 6 дугаар сарын 27

ПҮРЭВ

„Хөдөлмөрчдийн хууль эрхийн хүмүүжил ком-  
мунист хүмүүжлийн салтгүй бүрэлдэхүүн хэсэг  
мон. Энэ хүмүүжил социалист нийгмийн гишүүдийг  
ов тэгш хөгжилтэй болгон төлөвшүүлэх, социалист  
хууль ёс, социалист хамтын аж байдлын хэм хэмжээг  
чандлан сахих, нийгмийн дэг журмыг бэхжүүлэх  
иргэдийн хууль ёсны эрх ашиг сонирхлыг хамгаа-  
лах хүчин зүйл болж байна“.

МАХН-ын Төв Хорооны  
VIII бүгд хурал дээр нөхөр  
Ю. Цэдэнбалын хэлсэн  
үгсээс

## Аймгийн намын XVI бага хурлын ТОГТООЛ

1974-6-22

Зуунмод хот

### Аймгийн Намын хорооны ажлын тухай

Намын хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга нөхөр Ц.Адъяагийн тавьсан тайлан илтгэлийг хэлэлцээд бага хурлаас ТЭМ-ДЭГЛЭХ НЬ:

МАХН-ын программ болон XVI их хурлын шийдвэрт дэвшигдсэн дотоод, гадаад улс төрийн бодлогоо хэрэгжүүлэх, ЗСБНХУ, ах дүү социалист орнуудтай тогтоосон найрамдал, хамтын ажиллагаагаа бэхжүүлэх, эх орныхоо социалист байгуулалтын хөгжлийг түргэсгэх, хөдөлмөрчдийн аж байдал, соёлын хэмжээг дээшлүүлэх талаар Намын Төв Хорооноосоо авч хэрэгжүүлж байгаа практик арга хэмжээг тус аймгийн коммунистууд, нийт хөдөлмөрчид бүрэн дүүрэн сайшааж байна.

Аймгийн Намын хороо, тайлангийн хугацаанд МАХН-ын XVI их хурал, V таван жилийн төлөвлөгөөг биелүүлэхэд улс төр, зохион байгуулалтын ажлаа чиглүүлж үр нөлөөг нь дээшлүүлжээ.

Тайлангийн хугацаанд аймгийн нийт мал 83,0 мянгаар нэмэгдэж 1973 онд мал өсгөх хөдөлмөрийн төлөвлөгөөг 100,3 хувиар биелүүлж, 5 жилийн мал өсгөх төлөвлөгөөг хангах суурь дэвсгэр тавигдан ургацны төлөвлөгөөг нэр төрөл бүрээр 106,6-163 хувиар биелүүлэн, зарим аж ахуй төлөвлөлт, эдийн засгийн урамшуулалын шинэ системд шилжив.

Үйлдвэрүүд, нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэх 5 жилийн төлөвлөгөөний эхний 3 жил 5 сарын төлөвлөгөөг давуулж, ашигт ажиллагааны түвшин нэмэгдэн, ардын боловсрол, соёл, эрүүлийг хамгаалах байгууллагын зорилт амжилттай биелэгдэж байна.

Тайлангийн хугацаанд ЗХУ-ын хүч хөрөнгөөр үнээний иж бүрэн фермүүд, үтрэм, үрийн агуулахууд баригдаж, ЗСБНХОУ-ын Курган мужтай байнгын холбоо тогтоов.

Аймгийн Намын хороо, аж ахуйг удирдах, анхан шатны байгууллагуудын дайчин чадварыг дээшлүүлэх, эгнээний бүрэлдэхүүнийг сайжруулан зөв байрлуулж, манлайлалыг өндөржүүлснээр намын бүх гишүүдийн 72,4 хувь нь материаллаг үйлдвэрлэлийн хүрээнд ажиллаж, намын үзэл суртал, ухуулгын ажлын үр нөлөө дээшлэв. Эдгээр амжилтууд нь МАХН-ын байнгын удирдлага, ЗХУ-ын тал бүрийн тусламж, хөдөлмөрчдийн бүтээлч идэвх өрнөсний үр дүн юм. Гэвч бод мал өсгөх улсын төлөвлөгөөг тасалж суурьт 100 эхээс бойжуулах төлийн талаар Төв Хорооны IX бүгд хурлын заалтыг хангалтгүй хэрэгжүүлэн, 5 жилийн төлөвлөгөөний эхний 2 жилд улсад тушаах төмс, хүнсний ногоо, 5 төрлийн ноос, сүү тосны төлөвлөгөөг дутуу биелүүлжээ.

Үйлдвэрийн бүтээгдэхүүнийг нэр төрлөөр биелүүлэх явдал хангалтгүй, худалдаа, НААУ, эрүүлийг хамгаалах байгууллагуудын үйлчилгээнд соёлч шуурхай ажиллагаа дутагдалтай байна.

Социалист өмч, нийгмийн хөдөлмөрт хандах харилцаа, ухамсарын хэмжээ шаардлагаас хоцорч байна.

Энэ нь намын байгууллагуудаас үйлдвэрлэлийн нэгж, хөдөлмөрийн хамт олны дунд зохиох үзэл суртал, зохион байгуулалтын ажил чанаржиж хүмүүсийн ухамсар хариуцлагад бүрэн нөлөөлж чадаагүйтэй холбоотой гэж үзнэ.

Аймгийн намын XVI бага хурлаас ТОГТООХ НЬ:

НЭГ. Аймгийн Намын хорооноос тайлангийн хугацаанд зохион явуулсан практик үйл ажиллагааг зөв зүйтэй гэж үзсүгэй!

ХОЁР. 1974 онд мал өсгөх улсын төлөвлөгөөг төрлөөр нь биелүүлж, дүнгээр нь 1975 оны хэмжээнд хүргэх, өнгөрсөн гурван жилийн дундаас зүй бус хорогдлыг 40-өөс доошгүй хувиар багасган, 1975 онд ихэнх суурьт МАХН-ын Төв Хорооны IX бүгд хурлаас тавьсан зорилтыг хангах, таван жилд улсад тушаах ургацаас дутуу байгаа үр тариа, төмс, хүнсний ногоо, ноос, сүү тос зэргийг нөхөн биелүүлэх ба энэ талаар таван жилийн төлөвлөгөөг биелүүлэгчдийн туршлагыг нийтийн хүртээл болгож бүх нийтийн социалист уралдааныг өрнүүлэн улс төр, хөдөлмөрийн идэвхийг улам өрнүүлэх замаар тэргүүний аймгийн хэмжээнд хүрэх зорилтыг дэвшүүлсүгэй.

ГУРАВ. Аймгийн нам, улс, олон нийт, аж ахуй, соёлын байгууллагуудад ДААЛ-ГАХ НЬ:

1. V таван жилийн төлөвлөгөөт зорилтоос эхний 3 жил 6 сард дутуу биелэгдэж, тасарч болзошгүй байгаа үзүүлэлтүүд илангуйа бод мал, сүү, тос, ноосны төлөвлөгөөнд нарийн судалгаа хийж үлдэж байгаа хугацаанд бүрэн хангах тодорхой арга хэмжээ боловсруулан хэрэгжүүлсүгэй.

2. Малыг отор бэлчээрээр таргалуулах ажлыг далайцтай зохиож үр дүнг сайжруулж өргөн аялсаат, бэлчээрийг хуваартай ашиглах туршлагыг бүх сумдад нэвтрүүлэх.

3. Хашаа худгийн чанарыг сайжруулж, жил бүрийн 7 сарын 10-ны дотор иж бүрнээр барьж дуусгаж байх заншил тогтоох.

4. Эвчилгээ тэжээлийн цэгийн ажлыг сайжруулан, үр ашгийг дээшлүүлж, тэжээл зарцуулалтад тавих хяналтыг хүчтэй болгож, бэлтгэлд тушаах малын амьдын жингийн хэмжээг мэлчдэд тогтоон өгч, шагналт хөлд олгож байх.

5. ХАА-н нэгдлүүдэд мал аж ахуйн хэсгийг бүрэн зохион байгуулж СХ-ийн хөдөлгөөнтэй хослох.

6. Малын арчилгаа маллагаанд дэвшилт технологи, тэргүүн туршлагыг нуцалтгүй нэвтрүүлж хээл хаялт, сувайралт, хорогдол, нэгчээс ашиглах ашиг шимийн байдал, ялангуяа бод мал хээлтүүлийн ажилд судалгаа хийж, арга хэмжээ боловсруулан, малчдын төрөлжсөн зөвлөлгөөн, эмэгтэйчүүд, залуучуудын хөдөлмөр соёлын чуулга уулзалт зохиож үр дүнг тооцож байх.

7. Хөрсний салхи усны эвдрэлээс хамгаалах, химижүүлэх, ганд төсвөртэй эрт болцтой сортыг шалгаруулах, урлах, малын тэжээл, олон наст ургамал тариалж байх.

8. Социалист өмчийг хамгаалахад хөдөлмөрчдийн үүрэг хариуцлагыг дээшлүүлж, аймгийн хэмжээний байнгын биш өглөг авлагыг энэ онд багтаан шийдвэрлэж, цаашид гаргуулахгүй байх.

9. ХАА-н бүтээгдэхүүний чанарыг сайжруулж, нэгжээс авах ашиг шим, ургацыг нэмэгдүүлэн ашигт ажиллагааг хангаж, аж ахуйн тооцоо, арвилан хэмнэлт, анхан шатны бүртгэлийг нэвтрүүлж, нөөц бололцоогоо шанхан дайчилж санхүү-эдийн засгийн үр дүнг дээшлүүлэх.

10. Үйлдвэрлэлийн ажиллагааг механикжуулан, цагийн алдагдалтай тэмцэж, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх, худалдаа, нийтийн үйлчилгээнд дэвшилтэт хэлбэр соёлч байдлыг нэвтрүүлэх.

11. Сургалтын шинэ системийг тууштай хэрэгжүүлж, суралгын сурлага, хүмүүжил сургууль, бэлч, эцэг, эх, албан байгууллагын холбоог бэхжүүлж, элсэлт төгсөлтийн төлөвлөгөөг хангах, соёлын байгууллагаас үйлдвэрлэлийн нэгжилд зохиох улс төр, уран бүтээлийн ажлын агуулга нөлөөг дээшлүүлэх, эх нийлхыг хамгаалж, ариун цэвэр эмнэлэг гэгээрэл, урьдчилан сэргийлэх эрүүлжүүлэх ажлыг эрс сайжруулан Намын Төв Хорооны 118 дугаар тогтоолыг биелүүлэх явцад үндсэн өөрчлөлт гаргаж ажиллах.

ДӨРӨВ. Аймгийн Намын хороонд ДААЛ-ГАХ НЬ:

1. Намын гишүүдийн марксист-ленинист боловсрол, манлайлал, хариуцлагыг ямагт өндөржүүлж, намын эгнээг МХЗЭ-ээр дамжсан тэргүүний залуу, ажилчин, малчин, мэргэжлийн сэхээтнээр байнга өргөтгөн хуваарилалт байршилтыг сайжруулах.

2. Намын үзэл суртал зохион байгуулалтын ажлыг бригад, цех, суурьт төвлөрүүлж намын бодлогыг сум, байгууллага, хөдөлмөрийн хамт олон, хувь хүний тодорхой зорилттой нягт хослон хүмүүсийн социалист ухамсар, ёс суртахууныг төлөвшүүлэх, НА ШБ-ын дайчин чадварыг нэмэгдүүлж юуны өмнө бригадын хариуцлагатыг намын гишүүдээр бэхжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэх.

3. Намын байгууллагуудаас социалист уралдааныг удирдах үүрэг амалтын чанар, түүнийг биелэлтэд тавих хяналтаа сайжруулж 100 ба түүнээс давсан хувьтны хөдөлгөөнийг өрнүүлэх.

4. МАХН-ын Төв Хорооны VII, VIII бүгд хурлын шийдвэрийг хэлбэрэлтгүй хэрэгжүүлж, АХШ ба бусад байгууллагуудын шалган зааварлах ажил, дотоод хяналтын далайц, арга барил үр нөлөөг дээшлүүлэх.

5. Удирдах боловсон хүчин, мэргэжилтнүүдийг уралдаанд тодорхой үүрэгтэй оролцуулан, бүтээлч ажлын төлөвлөгөөтэй ажиллуулж, хариуцлага санаачилгыг эрс дээшлүүлэх.

6. Суртал нэвтрүүлэг, ухуулга, соёл хүмүүжлийн ажлыг малын суурь, үйлдвэрийн цех, тодорхой хүмүүст хүргэж, тэднээс улсын төлөвлөгөө, уралдааны үүргээ биелүүлэхэд чиглүүлэн, тэргүүн туршлага үзүүлэх сургуультай хослох ба хөдөлмөрчдийн эдийн засгийн боловсролын төвшинг дээшлүүлэх талаар дэс дараатай тодорхой ажил зохиох.

Мэдээллийн хэрэгслэлийг өргөн ашиглах, суурийн хүмүүжил, бригадын өдөрлөгийг улам чанаржуулж, хөдөлмөрчдийн дунд зохиох улс төр, хууль эрх, шашингүйн суртал нэвтрүүлгийг оновчтой болгож хүмүүсийн ухамсар дахь хуучин нийгмийн үзэл санааны үлдэгдэл, хөрөнгөтний болон харгис Мао-измын үзэл суртлын эсрэг шийдвэртэй тэмцэл явуулах.

7. Төрийн байгууллагын ажлын социалист ардчилал, хууль ёсыг хэлбэрэлтгүй

(Тогсгол нь II нүүрт)

# Аймгийн намын XVI бага хурлын ТОГТООЛ

## АЙМГИЙН НАМЫН ХОРООНЫ АЖЛЫН ТУХАЙ

Тогсгол. (Түрүүч нь I нүүрт)

бислүүлэн, хөдөлмөрчдийн хууль эрхийн хүмүүжлийг дээшлүүлэх, нийгмийн өмчийг хамгаалан ариунжуулах, хэв журмыг чанд сахуулах, иргэний үүргийн биелэлтийг дүүрэн хангуулахад чиглүүлэн хөдөлмөрчдийн дунд зохиох соёл хүмүүжлийн ажлын чанар далайцгүй нэмэгдүүлэх.

8. Олон нийтийн байгууллагын дотоод ажлыг бүх талаар сайжруулж, ҮЭ—ээс аж ахуйг эзэмдэхэд оролцох явдлыг идэвхжүүлэн, социалист уралдаан, СХ-ийн хөдөлгөөнийг төв, хөдөөд өрнүүлж ялангуяа тооцоотой үүрэг, угтвар төлөвлөгөө, социалист уралдааны

гэрээ зэрэг шинэ хэлбэрийг бүтээлчээр эзэмшиж тодорхой удирдах, хөдөлмөрч хамгаалал, соёл аж байдлын нөхцөлийг сайжруулах, ХЗЭ-ийн байгууллагууд түшиглэсэн байгууллагын төлөвлөгөөт зорилтыг биелүүлэхэд туслах, гишүүд, залуучууд илгээлтийн эзнийг ахмад үеийнхний хувьсгалч дайчин, хөдөлмөрч уламжлалаар хүмүүжүүлэх, эмэгтэйчүүдийн байгууллагууд өсвөрийн үеийнхний хүмүүжил, мэдлэг боловсрол, хөдөлмөрчин эмэгтэйчүүдийн дунд зохиох улс төр, олон түмний ажил, ахуйн соёлжилтыг дээшлүүлэхэд ажлаа чиглүүлэх.

ТАВ. МАХН-ын Төв Хорооны VIII бүгд хурал, Ардын Их Хурлын 8 дахь удаагийн

сонгуулийн III чуулганы шийдвэрийг сурталчлан биелүүлж, 1974 оныг аж ахуй, соёлын байгуулалтын бүх хэсэгт гавшгай ажил, өндөр бүтээлийн он болгох зорилт тавьж, тодорхой төлөвлөгөөтэй ажиллахыг нам, улс, олон нийт, аж ахуйн бүх байгууллагуудад даалгасгай.

МАХН-ын XVI их хурал, аж ахуй, соёлыг хөгжүүлэх 1974, 1975 оны төлөвлөгөө, бага хурлынхаа шийдвэрийг амжилттай биелүүлэхийг аймгийн нам, улс, олон нийт, аж ахуй, соёлын бүх байгууллага, намын гишүүд, орлогч гишүүд, хөдөлмөрчдөл аймгийн намын XVI бага хурал уриалж байна.

Аймгийн намын XVI бага хурал

## Аймгийн намын XVI бага хурал дээр МАХН-ын Төв Хорооны гишүүн Б. ЛАМЖАВ-ын хэлсэн үг

Төлөөлөгч НӨХӨД ӨӨ!

Аймаг, хотын намын хороодын ээлжит бага хурал хуралдаж байгаа нь манай намын амьдралд болж буй чухал үйл явдал мөн.

Төв аймгийн намын бага хурал үзэл суртал, зохион байгуулалтын өндөр хэмжээнд явагдаж, өөрийн өмнө тавьсан зорилтыг амжилттай шийдвэрлэв. Тус бага хуралд тавьсан аймгийн Намын хорооны тайлан илтгэл болон төлөөлөгчдийн хэлсэн үгэнд аймгийн өнгөрсөн 3 жилийн ажлын байдал, намын байгууллага, коммунистуудын үйл ажиллагаанд дүгнэлт хийж цаашдын зорилтыг тодорхойлон заалаа.

МАХН-ын XVI их хурал, аймгийн намын XV бага хурал хуралдсанаас хойших хугацаанд манай орны нийгэм улс төрийн амьдралд чухал ач холбогдолтой олон үйл явдал болсон байна.

Манай орны хөдөлмөрчид, коммунистууд МАХН-ын XVI их хурлын боловсруулсан намын, гадаад дотоод улс төрийн бодлогыг хэрэгжүүлэхийн тулд шаргуу хөдөлмөрлөж төрөлх хайрт МАХН-аа нягт хүрээлж, түүний Төв Хороо, нөхөр Ю. Цэдэнбал тэргүүтэй Намын Төв Хорооны Улс төрийн Товчооны үйл ажиллагааг бүрэн дүүрэн сайшааж байна.

Өнгөрсөн онд явагдсан БНМАУ-ын Ардын Их Хурлыг сонгох 8 дахь удаагийн сонгууль нь нам ард түмний бүрэн нэгдэл нягтралыг илэрхийлж, нийт сонгогч хөдөлмөрчид, намын гишүүн, гишүүн бусчуудын эвслээс нэр дэвшигдсэн депутатуудын төлөө 100 хувь саналаа өгсөн билээ.

1972 онд хуралдсан МАХН-ын Төв Хорооны III бүгд хурлын шийдвэрийг үндсэн саяхан хуралдсан БНМАУ-ын Ардын Их Хурлын 8 дахь удаагийн сонгуулийн III чуулганаар БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн даргаар манай нам, төр, олон улсын коммунист хөдөлгөөний нэрт зүтгэлтэн нөхөр Ю. Цэдэнбалыг санал нэгтгэж сонгосон явдал манай орны хөдөлмөрчид, коммунистууд баяр талархлаа илэрхийлж байна.

Энэ бол ЗХУ тэргүүтэй дэлхийн социалист системийн бүх талын хамтын ажиллагааг бэхжүүлэх болон манай оронд социализмыг бүрэн төгс байгуулах үйлст нөхөр Ю. Цэдэнбал, манай Намын Төв Хороо, Засгийн Газрыг олон жил толгойлон удирдахаа нам, ард түмний өндөр итгэл хүлээсний илэрхийлэл боллоо. Олон улсын тавцан дээр БНМАУ-ын эзлэх байр, нэр хүнд улам өсч манай нам, коммунист ажилчны намын нэгдэл нягтрал, нягт хамтын ажиллагааг бэхжүүлэхэд чухал хувь нэмэр орууллаа.

Ах дүү социалист орнууд юуны өмнө ЗХУ-аас манай орны социалист байгуулалтад үзүүлж буй интернационалч тусламж байнга өсөн нэмэгдэж байгааг баяртай тэмдэглэж байна.

Үүний нэг жишээ бол МАХН-ын III, улсын анхдугаар их хурал хуралдсаны 50 жилийн ойг тохиолдуулан тус орны хөгжил, ард түмний аж байдлыг улам дээшлүүлэхэд хувь нэмэр болгон эрхэм дээд бэлэг өгөх болсон нь биднийг улам баярлуулж байна.

ЗХУ-ын техник эдийн засгийн тусламж, Зөвлөлтийн ах дүү анд нөхдийн гар бие оролцоогүйгээр бий болсон үйлдвэр аж ахуй, соёл гэгээрлийн нэг ч салбар манайд байхгүй гэж хэлж болно.

Зөвхөн тус аймагт орчин үеийн иж төхөөрөмжөөр тохижсон ХАА-н нэгдэл, ТАА, сүүний фермүүд байгуулагдаж Зөвлөлтийн олон тооны мэргэжилтэн нар баялаг туршлагаа монгол нөхөддөө өвлөн эзэмшүүлж байна. ЗХУКН-ын XXIV их хурал болж социалист ах дүү орны коммунист ажилчны намын их хурлын шийдвэрт тусгалаа олсон дэлхий дахины энх тайвныг бэхжүүлэх программ хэрэгжин биелж урт удаан энх амгалан байдлыг тогтоох, зэвсэглэлийг нийтээр хорогдуулах, атом, устөрөгчийн зэвсгийг хориглох, Европ, Азид аюулгүй байдлыг тогтоох, үүссэн дайны голомтыг хэлэлцээрийн аргаар шийдвэрлэх талаар чухал алхамууд хийгдлээ.

Харин Маогийн бүлгийнхэн дэлхийн харгис хүчинтэй шууд нийлж, ЗХУ болон социалист бусад орны эсрэг хорт үйл ажиллагааг улам идэвхжүүлэн, олон улсын хурцадмал байдлыг намжаахад чиглэгдсэн бүх саналыг эсэргүүцэж байна.

Цөмийн зэвсгийг үйлдвэрлэхэд асар их хөрөнгө зарж улс орноо цэрэгжүүлэн Монгол—Зөвлөлтийн эсрэг дайсагнах ажлаа улам хүчтэй болгож байгааг манай нам эрс шийдвэртэй илчлэн няцааж байна.

Ийм байдалд дүгнэлт хийж, улс орныг батлан хамгаалах хүчийг бэхжүүлэх, улс төрийн сонор сэрэмжийг өндөр байлгаж, хятадын удирдагчдын улс төрийн бодлогын мөн чанар, үндсэрхэх дээрэнгүй үзэл, Марксизм—Ленинизмд харш үзлийн үндэс шалтгааныг хөдөлмөрчдөл тайлбарлах ажлыг манай намын байгууллага өөрийн чухал зорилт гэж үзэж байна.

НӨХӨД ӨӨ!

Өнгөрсөн 3 жилд манай ард түмэн, МАХН-ын XVI их хурлын шийдвэр, V таван жилийн төлөвлөгөөг биелүүлэх, давуулан биелүүлэх тэмцэлд гайхамшигт амжилт олоо. Үйлдвэр барилга, ХАА, соёл гэгээрэл, эрүүлийг хамгаалах талаар 3 жилийн төлөвлөгөөний гол зорилтууд амжилттай биелэгдэв. Манай орны хөдөлгөөний хөдөлмөрчид 1973 оны мал өсгөх, үр тариа, хүнсний ногоо хураан авах төлөвлөгөөг давуулан биелүүлээ. Нам, засгаас улс орны өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг хангах, хөдөлмөрчдийн материаллаг аж байдлыг дээшлүүлэхэд байнга анхаарал тавьж байна.

ХАА-г механижуулах, эрчимжүүлэх, мал аж ахуйн материаллаг баазыг сайжруулах талаар олон чухал арга хэмжээ авч ХАА-н нэгдлийн орлогыг нэмэгдүүлэхийн тулд нэгдлээс урьд гаргаж байсан зарим зардлыг улс өөртөө авах, МАА-н зарим бүтээгдэхүүний улсад худалдах үнийг нэмэх, ХАА-н нэгдлийн улсад төлөх зээлийг бүрэн буюу заримыг хөнгөлөх зэрэг арга хэмжээний үрээр зөвхөн Төв аймгийн ХАА-н нэгдлүүд 14 орчим сая төгрөгийн нэмэгдэл орлого олжээ. Мөн ХАА-н нэгдэл, САА-г мэргэжлийн боловсон хүчнээр хангах ажлыг байнга анхаарч байна.

Өнгөрсөн 3 жилд тус аймгийн ХАА-д дээд боловсролтой хүний тоо 19,3 хувь, тусгай дунд боловсролтой хүн 33,6 хувь, техник мэргэжлийн сургууль төгссөн 300 шахам хүн нэмэгдсэн байна.

Нам, засгийн дээрхи арга хэмжээ, олон тооны нэгдэл, САА, малчид, уралдаанд байр эзлэж, улс, аймаг, сумын шагнал хүртсэндээ урам зориг нь бадарсан манай хөдөлмөрч малчид нийт ард түмний социалист уралдааныг өрнүүлэн, улсын тэргүүний аймаг, сум-нэгдэл, САА, тэргүүний малчдын үлгэр дууриаллаар ажиллаж өмнөө тодорхой зорилт тавьж төлөвлөгөөг тоо чанараар нь давуулан биелүүлэх эх оронч хөдөлгөөн газар бүр өрнөж байна.

МАХН-ын Төв Хорооны VII бүгд хурлын шийдвэр, Намын Төв Хороо, Сайд нарын Зөвлөлийн тогтоол, н. Цэдэнбалын даалгаврыг биелүүлэх талаар нам, улсын байгууллагаас зохион байгуулалтын олон арга хэмжээ авч, малын төлийг хүлээн авах бэлтгэлийг хангах, малын зүй бусын хоргодлыг багасгах талаар мэдэгдэхүйц ахиц гаргалаа. Энэ оны 6 дугаар сарын 10-ны байдлаар улсын хэмжээгээр 8,6 сая төл бойжуулан авч малын зүй бусын хоргодлыг өнгөрсөн оны энэ үетэй харьцуулахад 43,3 хувиар багасгаж 1974 оны мал өсгөх төлөвлөгөөг давуулж биелүүлэх урьдчилсан нөхцөлийг бүрдүүлээ.

Мөн хаврын тариалангийн ажил хугацаандаа дуусч, үр тарианы соёлолт муутгүй байна. Улсын үйлдвэр, барилга, худалдаа, үйлчилгээ, тээвэр, холбоо, соёл гэгээрэл, эрүүлийг хамгаалах ажлын төлөвлөгөөт зорилт амжилттай биелж байна.

Төв аймгийн Намын хороо тайлангийн хугацаанд намын байгууллагын удирдах ролийг дээшлүүлэх, коммунистуудын манлайлыг сайжруулах, зохиож буй ажлын үр нөлөөг дээшлүүлэх талаар нилээд ажил зохиосон нь тайлан илтгэл, төлөөлөгчдийн хэлсэн үгнээс тодорхой байна.

Намын хороо юуны өмнө нам, улс, аж ахуйн салбарыг удирдах боловсон хүчнээр бэхжүүлэхэд зохих анхаарал тавьсны үрээр одоо аймгийн Намын хорооны аппаратын ажилтны 75 хувь нь, намын үүр хорооны нарийн бичгийн дарга нарын 87,5 хувь, сум нэгдэл, САА-н дарга нарын 82 хувь нь дээд боловсролтой, эдгээрийн нилээд нь ХАА-н дээд боловсролтой, намын ажил үйлдвэрлэл онолыг мэдэх туршилагатай ажилтан нар болсон байна.

Аймгийн Намын хорооны бүгд хурал, товчооны хурлаар газар тариалангийн үйлдвэрлэлийг удирдах удирдлагыг боловсруулж болгон дэвшилт арга технологийг нэвтрүүлэх тухай, нэгдлийн эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх гэх зэрэг гол асуудлуудыг хэлэлцэн, газар тариалан, мал аж ахуйн тодорхой асуудлаар туршилага практикийн үзүүлэх сургууль зохиох, социалист уралдааныг төрөл бүрийн хэлбэрээр өрнүүлж, тэргүүний хүмүүсийн арга туршилагын тухай аргачлал боловсруулан нэвтрүүлэх, эзэмшүүлэх ажлын зөв эхлэлт хийгдэж

(Үргэлжлэл нь III нүүрт)

# Нөхөр Б. ЛАМЖАВ-ын хэлсэн үгийн үргэлжлэл

Үргэлжлэл. (Түрүүч нь II нүүрт)

хамт олны идэвхийг өрнүүлэх багагүй ажил зохиожээ. Төв аймаг мал өсгөх V таван жилийн төлөвлөгөөний эхний 3 жилийн хөдөлшгүй төлөвлөгөөг нийт дүнгээр нь 100,3 хувиар биелүүлж, 1974 оны малын төл хүлээн авах ажлыг урьдахаас илүү зохион байгуулалттай явуулснаар одоо бүх эх малын 81 хувь төлөж гарсан төл 98,1 хувиар бойжиж малын зүй бүс хороогдлыг өнгөрсөн оны энэ үеэс 37,6 хувиар багасгасан байна.

Улсад тушаах үр тарианы 1973 оны төлөвлөгөө болон 1974 оны үр тариа, тэжээлийн ургамал тариалах төлөвлөгөөг давуулан биелүүлсэн байна.

Аймгийн үйлдвэр аж ахуй, соёл гэгээрлийн байгууллагуудын төлөвлөгөөт зорилт үндсэндээ биелэгдэжээ. Намын үзэл суртал зохион байгуулалтын ажлыг аж ахуйн зорилтыг биелүүлэхэд чиглүүлж, ажилдаа үр ашигтай арга хэлбэрийг хэрэглэн туршлага хуримтлуулж байгаа намын байгууллага нилээд байна. Өөрийн танилцсан байдлаас хэлэхэд Угтаалын САА-н намын хороо энэ 5 дугаар сард 5 жилийн төлөвлөгөөг яаж биелүүлэхээ тасаг, бригад, ферм, албан газар, тракторчин нэг бүрээр гаргаж, намын хорооны хурал, хамт олны зөвлөлдөөнөөр хэлэлцэн хоцорч буй салбарын төлөвлөгөөг биелүүлэх тодорхой арга хэмжээг авсан байна. Энд намын гишүүд хамт олныг идэвхжүүлэн хүн нэг бүртэй ажиллах явдалмуугүй, тус аж ахуй мал өсгөх V таван жилийн хөдөлшгүй төлөвлөгөөг 2 жилийн өмнө таван төрөл дээр нь биелүүлсэн, малын ашиг шимийг дээшлүүлэх талаар үндсэн эргэлт гаргаж хонины 70 хувь орчим нь эрлийз цэвэр үлдээр болж, ноос 1971 онд 56 тонн улсад тушааж байсан бол энэ онд 74 тонн болж, дунджаар 2 кг-д хүрсэн, малын тэжээл, хужирын асуудал бүрэн шийдвэрлэгдэж, өвлийн цагт зөөврийн усаар хангасан, газар тариаланд хөрсний элэгдэлтэй тэмцэх аргыг туршийн нэвтрүүлж, САА 1970 оноос эхлэн тогтвортой ашигтай ажиллаж 1973 онд 6,7 сая төгрөгийн цэвэр ашигтай, зөвхөн хонины ноосноос 1,1 сая төгрөгийн орлого олж байна.

Ажилчдын орлого нэмэгдэж 1973 онд олгосон нэмэгдэл хөлс үндсэн хөлсний 22 хувьтай тэнцэж байна. Сум, тасгийн төвийг тохижуулах эхлэлийг хийсэн байна.

Мөн ажлаа тогтмолжуулж, уралдаан өрнүүлэх, мэргэжилтэнтэй ажиллах талаар Жаргалант, Батсүмбэрийн САА-н намын хороо, зарим нэгдлийн намын үүрүүд нилээд ажил зохиосон байна.

Аймгийн намын бага хурал урьдах бага хурлаас Хойших хугацаанд олсон амжилтаа дүгнэхийн зэрэгцээ ажлын хоцрогдол, дутагдлыг хурцаар шүүмжилж МАХН-ын Төв Хорооны II, VII, VIII бүгд хурлын заалт, V таван жилийн төлөвлөгөөнөөс дутуу биелэгдсэн зүйлийг яаж биелүүлэх, энэ талаар ажлаараа хоцорч байгаа байгууллагын ажлыг тэргүүний хэсэгт хүргэхэд гол анхаарлаа хандуулах ёстой.

Аймгийн нам, улс, олон нийтийн байгууллагын удирдлагын хэмжээ, арга барилыг боловсронгуй болгон намын улс төр, зохион байгуулалтын ажлын үр нөлөөг дээшлүүлэх талаар зарим зүйлийг ярь.

Нэгдүгээрт. Таван жилийн төлөвлөгөөг бүрэн биелүүлэхэд 1 жил хагасын хугацаа үл-

дэж байна. Танай аймгийн гол үйлдвэрлэл бол мал аж ахуй, газар тариалан юм.

Мал аж ахуйн гол зорилт нь малын тоо толгой, бүтээгдэхүүний гарцыг нэмэгдүүлэх, улсад худалдах таварын бүтээгдэхүүний төлөвлөгөөг биелүүлэх явдал юм.

Үлдэж буй хугацааны төлөвлөгөөг биелүүлэх, мөн өнгөрсөн 3 жилд дутуу биелэгдсэн зүйлийг нөхөж гүйцэтгэх хариуцлагатай зорилт тус аймгийн нам, улс, аж ахуйн байгууллагын өмнө тулгарч байна.

Гаргасан судалгаанаас үзэхэд тус аймагт 5 жилийн төлөвлөгөөний гол 101 үзүүдэлтээс 40 гаруй зүйл биелэгдээгүй байна.

Ялангуяа 1973 онд байх ёстой малаас үхэр 19 мянга, адуу 23 мянга дутуу байна.

1973 онд тус аймагт гүүний 59, үнээний 33 хувь нь хээл хаяж сувайрчээ.

Уг ноцтой дутагдалд дүгнэлт хийж энэ онд үнээ гүүний хээлтүүлгийн ажлыг маш нарийн хяналт, зохион байгуулалттай явуулах ёстой байв. Гэтэл 6 дугаар сарын 20-ны мэдээгээр одоо хээл авсан байвал зохих үнээний 14,5 хувь, гүүний 21,5 хувь нь хээл авчээ гэснээс үзвэл хээл авахуулах ажил урьдын адил урсгалар явагдаж байна. Аймгийн үйлдвэр, барилга, худалдаа, тээвэр, холбоо, үйлчилгээний газрын төлөвлөгөө үүний дүнгээр биелсэн боловч үндсүүний нэр төрлөөр биелээгүй, чанар үзэмж шаардлагаас хоцорч байна.

"Аймгийн худалдаа бэлтгэлийн байгууллагын 1974 оны эхний хагас жилийн ажил хангалтгүй байна.

Худалдааны ажлын гол зүйл бараагүйлгээ 85 хувь, (зөвхөн 2 сум биелүүлжээ) ноос бэлтгэлийн ажил цаг алдаж байна.

Ноос бэлтгэх төлөвлөгөөг 3 жил дараалан тасалж байсанд нөлөөлөх ноцтой шалтгаан байсангүй. Энэ нь зөвхөн ажиллагааны муугаар тайлбарлахаас өөр аргагүй байна.

Гадаадад гаргадаг экспортын төлөвлөгөө тасрахад нэгдэл, САА-н удирдлага, худалдааны ажилтанд мараалын болон материалын талаар хүлээх хариуцлага байдаггүй байна. Энэ талаар цаашид холбогдох газрууд зохих журам боловсруулах нь зүйтэй. 1974 оны ноосны төлөвлөгөөг төрөл бүр дээр биелүүлэх цөөн хоногийн ажил зохиож дүгнэх хэрэгтэй.

Зуны удирлын сайхан байгаад санаа тайв шралгүй малын хорогдлыг багасгах, малыг отроор таргалуулах, МАА-н өвлийн бэлтгэл, хадлан тэжээл бэлтгэх ажлыг одооноос МАХН-ын Төв Хорооны VIII бүгд хурал дээр н. Цэдэнбалын хэлсэн үгэнд заагдсан шаардлагыг хангахаар зохион байгуулах хэрэгтэй.

Мөн 3 жилийн гүйцэтгэлээс үр тариа 16,0 мянган тонн, төмс 1018 тонн, хүнсний ногоо 4174 тонн дутуу байгааг үлдэх 2 жилд нөхөн биелүүлэх болж байна. Энэ бол хялбархан биелэгдэх зорилт биш. Чухамхүү нам, улс, олон нийтийн байгууллагын зохион байгуулалтын удирдлага, ажилчин малчин хүн бүрийн анхаарал чармайлтаас л шалтгаалах юм.

Намын хороо, үүр, аж ахуйн захиргаа МАХН-ын Төв Хорооны бүгд хурал, аймгийн намын бага хурлын шийдвэрийг биелүүлэх ажлыг юуны өмнө төлөвлөгөөт зорилтын дутууг бригад ферм, суурь албан үйлдвэрийн газар бүр дээр гаргаж судалгаа хийж намын гишүүд нийт ажилчид, малчид хамт олны хурлаар хэлэлцүүлж нөхөж биелүүлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх хэрэгтэй.

Хоёрдугаарт. Танай аймгийн нэгдэл, САА-н үйлдвэрийн эдийн засгийн үзүүлэлт дээшилж, алдагдалтай аж ахуйн тоо нилээд цөөрсөн байна. 1973 онд ХАА-н 4 нэгдэл, Баянцогтын САА алдагдалтай ажиллажээ. Аж ахуйн алдагдлын гол шалтгаан нь аж ахуйн ажиллагаа нарийн тооцоо муутай, аж ахуйн дотоод бололцоог муу ашиглах, гол нь малын ашиг шимийн ашиглалт дорой байна. Тус аймгийн нилээд аж ахуй сүүлийн 3 жил дараалан ноос сүүний төлөвлөгөөг тасалж байжээ. Үүнээс болж хагас сая төгрөгийн орлого авч чалдсангүй.

Малын үржлийг сайжруулах төлөвлөгөөг жил бүр тасалсан нь 100 үнээ, гүүнээс авах төл буурсантай холбоотой байна. 1971—1973 онд улсад нийлүүлэх сүүний төлөвлөгөөг 15—22 хувиар тасалж нэг үнээнээс саах сүү 1971—1973 онд нэмэгдсэнгүй.

Баянцогтын САА-д ЗХУ-ын тусламжаар тохилог ферм байгуулагдаж, өндөр ашиг шимтэй үнээ худалдан авч өгсөн боловч үнээний үүлдэр угсаа, саах сүүний нарийн норм тогтоох, үнээг тэжээх арчлах ажил муу, зоотехникч хандилтгүй, шаардгдах сайн чанарын тэжээл байхгүй байна.

Энэ фермийн ажил аймгийн ХААУ Газрын шууд хяналтад байвал зохино.

Энд зарим саальчин эрлийз нэг үнээнээс 3365 л сүү сааж байхад адилхан үнээг сааж буй олонхи саальчин түүнээс нэг дахин бага сүү сааж байгаа нь хүмүүсийн хариуцлага далаагаас болж байна.

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс «Цөцгийн тос, цагаан идээ үйлдвэрлэх ажлыг сайжруулах арга хэмжээний тухай» саяхан гаргасан тогтоолыг биелүүлэх, энэ оны сүүний төлөвлөгөөг заавал биелүүлэх, үүний тулд уралдааны нарийн болзол гаргаж саальчид, малчдын идэвхийг өрнүүлэх хэрэгтэй.

Ялангуяа сүү ногооны төлөвлөгөөг бүрэн биелүүлж, нийслэл хотынхоо 50 жилийн ойд Төв аймгийн хөдөлмөрдийн баяр талархлыг илтгэх нь зүйтэй.

Гуравдугаарт. Бүх ард түмний социалист уралдааныг өрнүүлэх тухай 1974 оны тогтоол, 1974 онд хуралдсан социалист уралдаанд түрүүлэгчдийн чуулга-уулзалтын уриалтыг хэрэгжүүлэх хөдөлгөөн улс орон даяар өрнөлөө.

Тэргүүний аймаг, сум, нэгдэл, САА-н малчид, ажилчдын туршлагыг нэвтрүүлэх ажлыг намын ажлын үндсэн арга болгож, аж ахуйн, тасаг бригад цех, мал аж ахуйн суурь, ферм нэг бүр төлөвлөгөөг жигд биелүүлэх хэрэгтэй байна.

Танайд 6 нэгдэл гурван жил дараалан мал өсгөх төлөвлөгөөг тасалдуулсан явдлыг ноцтой дутагдал гэж хэлж болно.

Аймгийн нам, улсын байгууллага, хоцорч яваа сум-нэгдэл, САА, үйлдвэр байгууллагыг анхаарч, товчоо захиргааны гишүүд хариуцан авч, нам, захиргааны бүх байгууллагаас биетэй туслах явдалд ажлаа чиглүүлбэл зохино.

Ер нь тогтоол шийдвэр, төлөвлөгөөний хувь заяаг тодорхой хүмүүс шийднэ. Тэгэхдээр малчин, ажилчин нэг бүртэй уулзаж, авах арга хэмжээг тэдэнтэй зөвлөн, тэдэнд ямар тусалцаа дэмжлэг хэрэгтэйг сонирхон хүн бүртэй ажиллах нь чухал. Сум, нэгдэл, САА, малчин, суурь бүрийн ажлыг тогтвортой, тогтворгүй, хангалтгүй ажиллагаагаар нь ялгаварлан судалж, түүний

(Төгсгөл нь IV нүүрт)



Аймгийн намын XVI бага хуралд төлөөлөгчөөр сонгогдон оролцсон хэсэг сайчууд. ЗУРАГ ДЭЭР: (Зүүн гараас) Баян-Өнжүүл сум-нэгдлийн алаачин Е. Лхам, Угтаалын САА-н трактор комбайнч С. Баточир, Монголморьт сумын "Улаанбаатар" нэгдлийн саальчин Г. Ханд, Лүн сумын "Энхтүүл" нэгдлийн хоньчин Ж. Рашондорж, Батсүмбэрийн САА-н саальчин Ч. Норов, Ойршорьт сумын "Хөгжил" нэгдлийн саальчин Ц. Насантогтох, Зууномд хотын худалдааны трестийн худалдагч С. Дагийсүрэн, Эрдэнэсэт сумын ТАА-н комбайнч Ц. Ухнаа

Л. ГУНГААБУУ-гийн өссөн өөрөл зураг

## Нөхөр Б. ЛАМЖАВ-ын хэлсэн үгийн төгсгөл

Тогтоол. (Түрүүч нь III нүүрт)

шалтгааныг хувийн ахуй, хүн бүрийн чадвар мал маллагааны арга, хувь хүний зан чанар, хөдөлмөрт хандах үзэл зэрэг олон асуудлаар судлаж, ажиллагаагаар хоцрогдож буй айл өрх, суурьтай нэг бүрчлэн ажиллаж буй тэргүүний нэгдэл, аж ахуйн туршлагыг нэвтрүүлэн ажиллах, малчин ажилчин нэг бүрийг хувийн тооцоотой болгох ажлыг бүх нэгдэл, аж ахуй заавал нэвтрүүлбэл зохино.

Дөрөвдүгээрт. МАХН-ын XVI их хурал, Улс төрийн Товчооны хэд хэдэн тогтоол, намын анхан шатны байгууллагын нарийн бичгийн дарга нарын улсын зөвлөлгөөнөөс намын бүрэлдэхүүнийг сайжруулах, гишүүдийн манлайлыг дээшлүүлэхийн чухлыг заажээ. Тус аймгийн намын байгууллага ажилчин, малчин гишүүдийн тоог нэмэхэд анхаарсны үрээр 1971 онд орлогчоор элсэгчдийн 33,5 хувь нь ажилчин, малчин байсан бол 1973 онд 58,4 хувь болсон байна. Гэвч Баян, Мөнгөнморьт сумын намын байгууллагууд тайлангийн хугацаанд малчдаас гишүүнээр элсүүлсэнгүй. Намын гишүүнд улс, аймаг, сум, үйлдвэрийн тэргүүний хүмүүс, залуучуудыг элсүүлэх, намын гишүүдн манлайлыг улам сайжруулах талаар их ажил хийх хэрэгтэй байна.

Намын Төв Хорооны II, VII бүгд хурлын заалтыг биелүүлж боловсон хүчнийг зөв шилж авах, хуваарилах, хүмүүжүүлэх ажлыг бүх салбар сайжруулах хэрэгтэй. Нам, улсын боловсон хүчний өмнө шинэ өндөр шаардлага тавигдаж байна.

Боловсон хүчний мэргэжил боловсролыг байнга дээшлүүлэх хэрэгтэй.

Нам, улсын удирдах ажилтныг давтан бэлтгэх ажлыг өөрийн оронд, ЗХУ-д хийж байгаа нь аж ахуйг удирдах, намын ажлын арга барилыг дээшлүүлэхэд чухал түлхэц болох ёстой. Нам, улсын боловсон хүчинд анхаарал халамж тавихыг зарчимч шаардлагатай зөв хослох, эрхэлсэн ажлын хариуцлагыг өндөржүүлэх, боловсон хүчин, хүмүүсийн ажлыг зохиосон ажлын тоогоор бус жинхэнэ үр дүнгээр нь шалгах ажлыг удирдлагын гол арга барил болгохыг Намын Төв Хорооны VII бүгд хурал заасан юм. Тус аймгийн боловсон хүчний дотор нам, улсын даалгавар төлөвлөгөөг таслаж, ажилд ёс төдий хандах, нүд хуурах, нам, улсын сахилга бат зөрчих явдал үзэгдсээр байна.

Танай аймгийн зарим нэгдэл, САА-д мэргэжлийн хүмүүсийн биеэ даасан ажиллагаа хувийн санаачлага төдий л сайжирсангүй. Үйлдвэрлэлийн ажлыг өдөр тутам биеллэн удирдах үүрэг бүхий дунд шатны удирдах ажилтан, бригад фермийн хариуцлагатны мэдлэг мэргэжил, ажлын арга барил, хувийн хариуцлага нилээд суманд хангалтгүй байгаад дүгнэлт хийж тэднийг зааж сургаж хүмүүжүүлэн ажилд нь туслах хэрэгтэй байна.

Мал өсгөх төлөвлөгөө, улсад тушаах бүтээгдэхүүний улсын даалгаврыг хэд хэдэн жил таслаж байсан явдал бол байгаль цаг уурын шалтгаанаас бус, харин тэдгээр сум—нэгдэл, САА-н нам, улс, аж ахуйн байгууллагын аж ахуйг удирдах удирдлагын арга барил өнөөгийн шаардлагаас хоцорч, МАА-н нөхөн үйлдвэрлэлийг сайжруулах,

эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх судалгаа тооцоо муу, ерөнхий баримжаагаар ажиллаж байгаагаар тайлбарлагдана.

Ажлынхаа арга барилд шүүмжлэлтэй, нам, улсаас хүлээлгэсэн найдварт хариуцлагатай хандахгүй, дутагдлаа, удаа дараа давтаж байдаг удирдах ажилтанд, нийгмийн эрх ашгийн үүднээс асуудал тавьж ажлаа сайжруулах хугацаатай даалгавар өгч байвал зохино.

МАХН-ын Төв Хороо сүүлийн жилд ажлын хариуцлагын байдлыг зарим яам, аймагт шалгаж чухал заалттай тогтоол гаргав. Эрүүлийг хамгаалах ажлын тухай, Дорнод, Сүхбаатар, Өвөрхангай, Хөвсгөл, Хэнтий аймгийн мал өсгөх төлөвлөгөөний биелэлтийн тухай асуудлаар тогтоол гаргаж, хариуцлага алдсан хүмүүст эзмлэл өгсөн юм. Энэ тогтоолын заалтаас дүгнэлт хийж ажлын хариуцлагыг сайжруулах явдал чухал юм. Нам, улсын тогтоол даалгавар улсын төлөвлөгөөний биелэлт тавих намын хяналтыг хүчтэй болгох, хянан шалгах байгууллагын үүрэг ач холбогдол, ажлын бүх салбарт зарчимч шаардлагыг өндөржүүлэх хэрэгтэй.

Тавдугаарт. Намын ажлын гол фронт болох нийгмийн эдийн засгийн хөгжлийн асуултын чухал хэсэг нь хамт олны нийгэм, оюун санааны хэрэгцээг хангах явдал юм. Нийгмийн хөдөлмөрт ухамсартай хандах үзэл ухамсарыг дээшлүүлэх талаар намаас үлэмж анхаарч ирсэн юм.

Хөдөлмөрчдийн нийгэмч ухамсар өсөн нэмэгдсээр байна.

Энэ нь намын олон жилийн ажлын том үр дүн мөн. Намын суртал ухуулга хүмүүжлийн ажлын үр нөлөөг дээшлүүлэх талаар 1972 онд болсон тэргүүний суртал нэвтрүүлэгч, ухуулгагчдын улсын зөвлөлгөөн, МАХН-ын Төв Хорооны 1972 оны «Малчдын дунд зохиох хүмүүжлийн ажлын тухай» тогтоолыг биелүүлэх талаар зохиосон ажлын олон хэлбэр бүл боловч түүний агуулга чанар үлдэц бага, хэлбэрлэх, ёс болгох хандлага үзэгдэж байна.

Зарим суманд танилцсан байдлаас үзэхэд бригадын өдөрлөг, суурийн хүмүүжлийн ажлын тоо их байх боловч нам, засагсаа мал аж ахуйн талаар гаргасан тогтоол шийдвэр, саяхан хуралдсан Төв Хорооны бүгд хурал, Ардын Их Хурлын чуулганы шийдвэрийг малчид байтугай мэргэжилтэн нарын зарим нь мэдэхгүй байв.

Ялангуяа ухуулгын ажлын чухал хэрэглүүр радио цэгийн хүрэлцээ муу, нилээд хэсэг нь тогтмол ажиллахгүй, суурь малчдын хөвлөл 2—5 долоо хоног болж тараагдаж байна. Намын хороо, захиргаанаас гаргасан шийдвэрийг хүн нэг бүрт хүргэж таниулах, тавигдсан зорилтыг биелүүлэхэд хамт олныг урьдаас бэлтгэх суртал хүмүүжлийн ажил бүрэн зохиогдохгүй байна.

Уралдааны үүрэг амлалт, тэргүүний хүмүүсийн ажлын арга туршлагыг сурталчлах ажил хангалтгүй байна.

Ухуулга хүмүүжлийн ажил цаг үедээ оновчтой, дайчин шуурхай зохиогдохгүй байгаагаас нийгмийн хөдөлмөрт хандах социалист ухамсар дутагдталтай, хөдөлмөрөөс зайлах, хувийн ашиг хичээх явдал арилаагүй байна. Тус аймгийн нилээд сум, албан байгууллага айл өрхийн соёлжилт, тэргүү-

ний аймаг сумдаас, говийн бүсэд оршдог аймаг сумдаас ч зарим талаар хоцрогдонгүй байгааг хэлэх нь зүйтэй.

Тус аймгийн Лүн зэрэг зарим сумдын төвийн албан байгууллагын контор, улаан булан, дэлгүүр, хоолны газруудаар ороход хаалга үүд нь эвдэрхий, хог тоосонд дарагдсан, орчны тохижилт хангалтгүй, хөдөөгийн айл өрхийн ариун цэвэр муу байна.

Соёлжилт, эрүүл ахуйн хүмүүжлийн ажил ийм байгаа нь элдэв халдварт өвчин үүсэхийн нэг шалтгаан болж, тус аймагт шарлах өвчин нилээд их хэмжээтэй байна.

Хөдөлмөрчдийн дунд зохиох хүмүүжил, соёлжилтын ажлыг сайжруулах талаар аймаг сумын удирдах байгууллагаас тодорхой ажил зохиож энэ талаар эрс өөрчлөлт гаргах хэрэгтэй. Улс төр, хүмүүжлийн ажилд удирдах ажилтан мэргэжилтэн, хариуцлагатан нарыг идэвхтэй оролцуулбал зохино.

Зургадугаарт. Саяхан БНМАУ-ын Ард Их Хурлын ээлжит чуулган хөдөлмөрчдийн хууль эрхийн хүмүүжлийн ажлыг сайжруулах тухай маш чухал асуудал хэлэлцэж тодорхой шийдвэр гаргасан хууль эрхийн хүмүүжлийн асуудал бол нэг талаас хөдөлмөрчдийн хууль ёсны эрхийг хүндэтгэн хамгаалах, нөгөө талаас иргэн бүхэн хууль тогтоолыг гуйвалтгүй биелүүлэх, нийгмийн хэв журмыг хатуу сахих хүмүүжил олгох чухал ач холбогдолтой юм.

МАХН-ын Төв Хороо, нийгмийн өмчийг хамгаалах, нийгмийн хэв журам зөрчилдтэй тэмцэх арга хэмжээний тухай тогтоолууд гаргав.

Энэ талаар Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлиг гарсныг та нөхөд мэдэх юм. Танай аймаг бол гэмт хэрэг, зөрчлийн хувьд бусад аймагас илүү үүний дотор аймгийн төв, Дэлгэрхаан, Батсүмбэр, Баянчандмань, Эрдэнэ сумдад зөрчил гаргах явдал нилээд байна.

Гэмт хэрэг зөрчилтэй тэмцэх тухай МАХН-ын Төв Хорооны тогтоолыг биелүүлэх, хөдөлмөрчдийн хууль эрхийн хүмүүжлийн ажлыг сайжруулах асуудлыг намын байгууллагын хурлаар зориуд хэлэлцэж нам, олон нийтийн байгууллага, засаг захиргаа хуулийн байгууллагаас зохиох ажлыг хүчтэй болгох хэрэгтэй.

Бүх салбарт бүртгэл тооцоог сайжруулан, нийгмийн өмч хөрөнгө үрэгдэх замыг хаах, одоо байгаа өр авлагыг барагдуулан нийгмийг хохиролгүй болгох нь чухал.

1974—1975 оны төлөвлөгөө зорилтыг хугацааны өмнө биелүүлэх, давуулан биелүүлэх, ажлын бүх салбарт зохион байгуулалт сахилга батыг сайжруулах, бүх шатны боловсон хүчний хувийн хариуцлагыг дээшлүүлэхэд намын байгууллагын ажил бүрэн чиглэгдэх ёстой гэж Намын Төв Хорооны VII бүгд хурал заасан юм.

Тус аймгийн намын бага хурал аймгийн нийт хөдөлмөрчид, коммунистуудын өмнө тодорхой зорилтыг дэвшүүлэн тавилаа. МАХН-ын III их хурал, БНМАУ-ыг тунхагласны 50 жилийн ойг угтсан социалист уралдааны эрчимтэй өрнүүлж, V таван жилийн төлөвлөгөөт зорилтыг биелүүлэх, намын үзэл суртал, зохион байгуулалтын ажилд шинэ амжилт гаргаж, аймгийн намын, XVI бага хурлынхаа шийдвэрийг биелүүлэх хэрэгт их амжилт гаргана гэдэгт итгэж байна.

## УРАН ХАГАЛААЧДЫН УРАЛДААН БОЛОВ

Аймгийн ХЗЭ-ийн хороо, ХАА-г удирдах газар, УЗ-ийн зөвлөлөөс хамтран аймгийн уран хагалаачдыг шалгаруулах 5 дугаар уралдааныг саяхан Архустын ТАА-д явууллаа.

Уран хагалаачдын энэ уралдаанд Угтаалын САА-н тракторчин, БНМАУ-хөдөлмөрийн баатар, улсын уран хагалаач-

дын уралдааны хоёр удаагийн аварга Г. Алтанхүү, Жаргалантын САА-н тракторчин, улсын уран хагалаачны 1972 оны аварга, 1973 онд БНАГУ-д болсон ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудын уран хагалаачдын анхдугаар уралдаанд амжилттай оролцсон Ц. Амгаабазар, Архустын ТАА-н тракторчин, 1973 оны тэмцээний хүрэл медальт

Г. Батсүх нарын шилдэг тэргүүний уран хагалаачид оролдов.

Уралдаанд эрэгтэйчүүдээс Жаргалантын САА-н С. Ганбаатар, эмэгтэйчүүдээс Жаргалантын САА-н Ц. Цэрэндулам нар нэгдүгээр байр эзэлж аймгийн 1974 оны аварга болж олоо. Баянцогтын Б. Чулуунбаатар, Угтаалын Г. Алтанхүү, нилгээлтийн эзэн Л. Нан-

салмаа, Архустын Д. Хүрэл-Жаргалантын САА-н Гансүх нар 2,3 дугаар байр эзлэв. Эдгээрээс гадна уран хагалаачдын уралдаанд амжилттай дайнд оролцохоор шалгаралдсан Архустын ТАА-н загдгараа, Амарбаясгалан,

Д. ОТГОН

ХАРИУЦЛАГАТАЙ ЭРХЛЭГЧ

Д. ТОВУУ

## ЗАРЛАЛ

Эрдэнэсант сумын харъяат Хаян овогтой Баатар нь тахир дутуугийн тэтгэвэр авах эрхийн 04634 номын дэвтрээ гээгдүүлсэн тул хүчингүйд тооцов.